



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 370

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Дарханы дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 404.0 (дөрвөн зуун дөрөв) сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны А-1/66 дугаар албан даалгаврын хэрэгжилт 93.6 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсүгэй.

2.“Дарханы дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3.“Дарханы дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал (Д.Батжаргал)-д дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

3.1.Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

3.2.Компанийн орлого, зардал, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний өөрчлөлтийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан эрх бүхий байгууллагад хүргүүлэн ажиллах;

3.3.Төрийн өөрийн өмчийн байр талбай болох цайны газрын сонгон шалгаруулалтын журмаар зохион байгуулах, ашиглалтыг сайжруулах, түрээсийн орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

3.4.Техникийн нөхцөл олголтын он дамжсан 1.3 (нэг сая гурван зуун мянга) сая төгрөгийн авлагыг барагдуулах, техникийн нөхцөл олголтын журамд урьдчилгаа төлбөр авах, гэрчилгээг төлбөрөө бүрэн барагдуулсны дараа олгох асуудлаар нэмэлт заалт оруулж батлуулах;

3.5.Компанийн хэмжээнд гүйцэтгэх захирал, Төлөөлөн удирдах зөвлөлөөс батлуулан мөрдөж байгаа журам, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад үзүүлэх ажил үйлчилгээний тариф тогтоосон тушаал шийдвэр, Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газраас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн баталсантай уялдуулан холбогдох журмуудад өөрчлөлт оруулах, шинэчлэн батлах;

3.6.Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй, 1 жил ба түүнээс дээш хугацаатай авлагыг барагдуулах, цаашид найдваргүй авлага үүсгэхгүй ажиллах;

3.7.Компанийн эзэмшлийн 4690 м2 буюу 6 ширхэг эзэмших ашиглах эрхийн газрыг үнэлж санхүүгийн тайланд бүртгэх.

4.Тогтоолын биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

5.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ,
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн
270 дугаар тогтоолын хавсралт



“Дарханы дулааны сүлжээ” төрийн өмчит компанид
хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг
арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчлийн утга	Мөнгөн дүн (сая төгрөгөөр)	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөнд тусгаж, батлагдаагүй зардлыг санхүүжүүлсэн.	0.0	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11.8, 20.3 дах заалтыг мөрдөн ажиллах.
2	Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөт ажлууд хугацаандаа хийгдээгүй, он дамжсан, зарим ажлын бүрдэл дутуу.	178.9	Хууль гэрээнд заасны дагуу хариуцлагын арга хэмжээг авч хэрэгжүүлэх, шаардлагатай бол хууль хяналтын байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх.
3	Худалдан авах ажиллагааны хуулийг зөрчсөн.	225.1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйл, Сангийн сайдын 2021 тушаалаар баталсан 102 дугаар журмыг мөрдөн ажиллах.
4	Компанийн эзэмшил/ашиглалт бүхий газрын үнэлгээг хийж санхүүгийн тайланд тусгаагүй.	6 газар, 4690 м2	Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тогтоолын дагуу үнэлж, Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолд заасны дагуу бүртгэлд тусгах.
	НИЙТ ДҮН:	404.0 (Дөрвөн зуун дөрвөн сая төгрөг)	

-----oOo-----